# БАЯНТАЛ СУМЫН 14 ХОНОГИЙН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ



**2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 04 дүгээр сарын 30-ний хооронд хийгдсэн ажлуудаас**

# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Цэргийн төв эмнэлэгийн эмч нар 2023 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр манай аймагт ирж ажилласан.Тус арга хэмжээний үеэр “Цэргийн алба хаах насны иргэдийн эрүүл мэндийн байдал” тулгамдсан асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний сургалтад хамрагдсан.

Мөн сумаас Хөгжлийн бэрхшээлтэй 3 иргэнийг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт оруулж цэргийн албанаас 07 дансанд 66,7 хувь бүртгэгдсэн.

2023 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр аймгийн Мал эмнэлгийн газраас сумын сонгогдсон малчдын 10 өрхийн 160 малаас шүлхийн бог малын мялзан өвчний байгалийн халдвар илрүүлэх тандалт шинжилгээнд цусны дээж цуглуулах ажил хийгдсэн байна.

Тухайлбал:

Хонь-60, Ямаа-40, Тугал-40 хамрагдсан байна.









# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Засаг дарга , Засаг даргын Тамгын газарт ирсэн, явсан, хариутай албан бичиг, өргөдөл гомдолын шийдвэрлэлтийн талаар:

- **1. Ирсэн албан бичиг -21**
- -Үүнээс: Бүртгэл хяналтын карт хөтөлсөн хариутай албан бичиг -6
- Хугацаандаа явсан хариутай албан бичиг -3
- Хугацаа хоцорсон -1
- Хугацаа болоогүй-2
- **2. Явуулсан албан бичиг-13**

**3. Өргөдөл, гомдолын шийдвэрлэлт**

**1. Засаг даргад ирсэн өргөдөл-2**

- -Шийдвэрлэх хугацаа болоогүй өргөдөл-2
- 1. Ажлаас чөлөөлөгдөх хүсэлт-1 /шийдвэрлэлтийн хугацаа болоогүй/
- 2. Баянхонгор аймгаас адуу авчрах зөвшөөрөл олгож өгнө үү-1 /шийдвэрлэх хугацаа болоогүй/
- **2. Засаг даргын Тамгын газарт ирсэн өргөдөл -2**
- Хугацаандаа шийдвэрлэсэн өргөдөл-1
- -Шийдвэрлэх хугацаа болоогүй өргөдөл-1

1. Тэтгэмж хүссэн -1

2. Зоорийг эзэмших хүсэлт-1/шийдвэрлэх хугацаа болоогүй/

- **ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:**

- Өмчлөлийн газраа худалдан борлуулж буй 1 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.

- Эзэмшлийн газраа эгүүлэн сэргээхийг хүссэн 2 өргөдлийг хүлээн авч шийдвэрлэн гэрээ, гэрчилгээг гарган өгч ажилласан.

- 4 Иргэний өмчлөлийн материалыг хүлээлгэн өгсөн.

Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Монгол улсын иргэнд 2023 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай” тогтоолын хэрэгжилтийг хanган 58 иргэнд газар өмчлүүлж, 1 иргэний эзэмшиж буй газрыг өмчлүүлэхээр ажиллаж байна.









# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

1. 2023 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улсын Засгийн Газраас санаачлан боловсруулсан Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзоригоор ахлуулсан ажлын хэсэг

2. аймгийн Засаг дарга Г.Батсуурь ”Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд хэрэгжүүлж буй “Нээлттэй Говьсүмбэр аймаг” хөтөлбөрийн хүрээнд хийгдэх томоохон төсөл хөтөлбөр болон Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг танилцуулсан.

/Тус хэлэлцүүлэгт 20 албан хаагч оролцсон байна/









# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

- 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр иргэний танхимд аймгийн "Насан туршийн боловсрол" төвөөс төрийн албан хаагчдад харилцааны сэтгэл зүй, биеийн хэлэмж сэдвээр сургалт зохион байгуулсан байна./Сургалтад-14 албан хаагч хамрагдсан/
- 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр сумын иргэний танхимд ИТХ-ын ажлын албанаас албан байгууллагуудын дарга, бичиг хэрэг хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтнуудад "Мэдээ бичих, түгээх арга зүй" " Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам" сэдвээр сургалт зохион байгуулалаа. /Сургалтад-9 албан хаагч хамрагдсан/










# “ХИЛИЙН ДЭЛГЭРЭХ” ХХК МАЛ ЭМНЭЛЭГИЙН АЖЛЫН ТАЛААР:

Сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/23 дугаар Захирамжийн дагуу 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрөөс 05 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх өдрүүдэд сэг зэм устгалын ажлыг сумаас эхлэн зохион байгуулахаар ажлын хэсэг томилодсоны дагуу “Хилийн дэлгэрэх” ХХК-тай 6,514,000 төгрөгийн гэрээг байгуулж 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр сумын хэмжээнд малын "Сэг зэм" устгах ажил эхэлсэн.

- 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр “Хилийн Дэлгэрэх" ХХК нь 2 дугаар ээлжийн сэг зэмийг 16 дугаар зөрлөгт зохион байгуулж 4 туслах ажилтан, 2 техник хэрэгсэлтэйгээр нийт 210 километр явж, үхэр 8, адуу 12, тэмээ 3, ямаа 14, хонь 42, зээр 15 нийт 94 малын сэг зэм, 13 кг ариутгалын бодис хэрэглэн, халдваргүйжүүлэлт хийн булж устган ажилласан байна. 2 дугаар багийн иргэн Ц.Доржбат сэг зэм устгахад хамтран ажиллаж дэмжлэг үзүүлсэн байна.
- 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр малын гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтын вакциныг "Хилийн Дэлгэрэх" ХХК нь 310 км явж 1420 үхэр буюу 44,8 хувийг одоогийн байдлаар вакцинд хамруулсан байна.
- Нийт хамрагдвал зохих: 21 өрхийн 3167 үхэр Одоогийн байдлаар хамрагдсан: 1420 буюу 44,8 хувь








# ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ:

### Амбулаторийн үйлчилгээ:

- Нийт үзлэг-241
- Амбулаторийн үзлэг -138
- Үүнээс:
- Идэвхитэй хяналт -6
- Өдрийн эмчилгээ-9
- Гэрийн эмчилгээ-5

  Урьдчилан сэргийлэх үзлэг- 92
- Нярайн гэрийн эргэлт-4
- Нярайн вакцинд хамрагдсан байдал-2,3,5 сартай нярай-10 хүүхэд

  Томуу- 2
-

### Түргэн тусламжийн дуудлагын төрөл, тоо хэмжээ:

- Нийт дуудлага -10
- Алсын дуудлага -2
- Төвийн дуудлага -8
- Том хүн -6
- Хүүхэд-4
- Осол гэмтэл-0

### Стационарийн үйл ажиллагаа:

- Хэвтэн эмчлүүлэгчид нийт-6
- Дотор -6
- Хүүхэд -0
- Халдварт-0

### Лабораторийн үзлэгийн тоо: 91/давхардсан тоо/

-Сахар холестролийн хэмжээ тодорхойлох түргэвчилсэн оношлуур-19, зөрэг-1

-Элэгний B,C вирус тодорхойлох шинжилгээ-17, эрэгтэй10, эмэгтэй-7, зөрэг-1

-Шээсний ерөнхий шинжилгээ -24

-Цусны ерөнхий шинжилгээ-22 эрэгтэй-13, эмэгтэй-9

-Цагаан хорхойн шинжилгээ хүүхэд-1, том хүн-1

Биохими эмэгтэй-2, эрэгтэй-1

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ:

2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай танилцаж Эрүүл мэндийн газрын дарга, сумын Засаг дарга, сумын Эрүүл мэндийн төвийн дарга нар хамтран ажиллах гурвалсан гэрээг байгууллаа.

Аймгийн холбогдох албаны хүмүүс, эрүүл мэндийн төвийн ажилчдад арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүллээ.

















# УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГ:

- 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Сумын удирдах ажилтны шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 0-17 насны хүүхдийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийг 2023 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр зохион байгуулж үзлэг 67,1 хувьтай үргэлжилж байна.
- Нийт 441 хүүхэд хамрагдахаас-296 хүүхэд хамрагдсан.
- Мэдээлэл баталгаажсан-147
- Сургуулийн өмнөх боловсролын 2-5 насны 3 бүлгийн 71 хүүхэд 100 хувь үзлэгт хамрагдсан.
- Ерөнхий боловсролын сургуулийн 6-17 насны 157 хүүхэд 100 хувь үзлэгт хамрагдсан.
- 0-2 насны 68 хүүхэд
- Нийт хамрагдсан хүүхдийн тоо-296
- Үзлэгт хамрагдсан хувь- 67,1 хувь














# ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТАЛААР:

2023 оны ОНХСангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх худалдан авалтын ажлын хэсгүүдэд иргэдийн төлөөллийг оруулж өгсөнөөр иргэдийн оролцоотой хяналтыг сайжруулж ОНХСангийн хөрөнгөөр хийж буй ажлуудын үр ашгийг нэмэгдүүлэх, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж Захирамж бүрд иргэний төлөөллийг оруулсан.

1. Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн А/26 захирамжаар **“Камер шинээр авах, засварлах ажил”-**ын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ажлын хэсэгт Лүн багийн иргэний төлөөллийг оруулсан байна.

2. Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн А/27 дугаар захирамаар **“Эко паркийн хашаа шинээр барих ажил”-**ын гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Лүн багийн иргэний төлөөлөлийг оруулсан.

3. 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр “Эко паркийн хашаа шинээр барих ажил”-ын 38,000,000 төгрөгийн нээлттэй тендэрийг зарласан.







# ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР:

**Хаваржилтын ерөнхий нөхцөл байдал:**

Энэ хавар өөрийн сумын 88 малчин, 72 мал бүхий өрхийн 72035, гадны отрын 1540 нийт 73575 толгой мал хаваржиж байна. Нийт 29020 мал төллөхөөс 2023.04.28-ний байдлаар 18482 мал төллөн унага 63, тугал 120, хурга 15349, ишиг 2950 толгой нийт 18482 төл хүлээн авсан. Мал төллөлт 63,7 %, төл бойжилт 100 %-тай байна.Сумын аюулгүй нөөцийн өвс дууссан, 12 тн 2 жил өнжсөн тэжээлтэй байна.

**-Отор нүүдэл, зөвшөөрөлгүй нэвтэрсэн өрх, малын тоо:**

Төв аймгийн Баян сумын 1 өрх, Дундговь аймгийн 6 өрхийн болон эзэнгүй нийт 10000 гаруй толгой мал отроор ирж хаваржиж байгаа бөгөөд тус айлуудад бэлчээр нутаг чөлөөлөх тухай сумын Засаг даргын албан мэдэгдэл хүргүүлсэн. Одоогийн байдлаар зөвшөөрөл авсан отрын малчин байхгүй байна.

**-Малын өвчний байдал, тайван эсэх:**

Одоогоор малын өвчлөл гараагүй тайван байна.

**-Цаг агаарын аюулт үзэгдлийн мэдээ дамжуулж байгаа мэдээлэл**:

Цаг агаарын мэдээ болон аюулт үзэгдлийн мэдээг Баянтал ХААТ дундын групп, багуудын Засаг дарга нар болон багийн цахим хаягаар мэдээллийг тогтмол хүргэж хэвшсэн. Мөн WHAT 3 WORDS апликэйшний талаар малчдад мэдээлэл хүргэсэн.

-**АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН** шийдвэрээр сумдад хуваарилагдсан 1000 боодол үнэгүй өвсийг 2023 оны 04 дүгээр сарын 18-ний өдөр 1, 2-р багийн нийт 139 малчин мал бүхий өрхөд олгосон байна. Мөн хямдралтай үнээр борлуулж байгаа өвснөөс сумын 6 малчин өрх 180 боодол өвс худалдан авсан.








# БОЛОВСРОЛЫН ТАЛААР:

## ЕБСургууль нь:

1.Иргэний танхимд аймгийн "Насан туршийн боловсрол" төвөөс сургуулийн 6-9-р ангийн хүүхдүүдэд сургалт зохион байгуулсан байна.

2.Сургуулийн хүүхдүүдийн дунд "Стем сургалтын багц" үйл ажиллагаа болж байна.

3.Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор **"Нийтийн хөлбөмбөг"** төслийн хүрээнд МХБХ-ны U10, U11, U12 **"GRASSROOTS CUP 2023"** тэмцээнд Баянтал сумын сургуулийн хүүхдүүд багаараа оролцож "Орон нутгийн шилдэг баг"-аар шалгарч Алтан медалийн эзэд боллоо.




4.Хүмүүн бичиг сонинг Баянтал ЕБС-ийн нийт 27 ажилтан, албан хаагч бүгд захиалсан байна.

5.ЕБСургуулийн Г.Энхтунгалаг багштай 7а ангийн сурагчид сайн үйлсийн аянд нэгдэж сумын өндөр настан С.Сувд-д олон тооны шуудай аргал түүж өгч дэмжлэг үзүүлсэн байна.











# БОЛОВСРОЛЫН ТАЛААР:

## Сургуулийн өмнөх боловсрол нь:

1. 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр **“Нээлттэй хаалганы өдөрлөг”**-ийг зохион байгуулан 3 бүлгийн 45 эцэг эх, асран хамгаалагч буюу нийт эцэг эхийн 63,3% оролцлоо. Тус нээлттэй хаалганы өдөрлөгөөр эцэг, эх, асран хамгаалагч нарт “Хүүхэд хамгаалал”, “Хүүхэд хамгааллын баг гэж юу вэ?”, “Багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд эцэг эхийн оролцоо”, “Хүүхдийн хоол хүнсний илчлэг” сэдвүүдээр сургалт явуулан хоолны амталгааг хийлгэсэн.
2. 2023 оны 04 дүгээр сарын 17-21 ны өдрүүдэд багшийн гүйцэтгэлийн үнэлгээ явагдлаа. Тус үнэлгээнд 2 багш, боловсролын үнэлгээний төвөөс сонгогдсон 18 хүүхэд, 18 эцэг эх 100 хувь хамрагдсан.






# СОЁЛ УРЛАГИЙН ТАЛААР:

2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Аймгийн Насан туршийн боловсролын төвтэй хамтран иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх, нийгмийн идэвх оролцоо, санал санаачлагыг нэмэгдүүлэх зорилгоор угийн бичиг хөтлөх, Боржигин өв соёлыг сурталчлах, Монгол бичгийн анхан шатны мэдлэг олгох, “Түмэн дасгал” гэх мэт 7-төрлийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд төрийн албан хаагчид, иргэд 27 хүн идэвхтэй хамрагдлаа.

-Сумын иргэдийн сургалтын хэрэгцээг тодорхойлох санал асуулгыг байгууллагын цахим хаягаар иргэдээс авч байна.

Боржигин өв соёлыг сурталчилах ажлын хүрээнд өөрсдийн бэлтгэсэн “Боржигин уртын дуу”, “Өвлөн уламжлагч” цахим контентуудыг тогтмол олон нийтийн сүлжээгээр болон байгууллагын пэйж хуудсаар дамжуулан иргэдэд түгээж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 1022 хандалт авсан байна.












# ТАЛЫН ИЛЧ ОНӨААТҮГазар :

Байгууллагад нийт 6 дуудлага ирсэн бөгөөд үүнд:

-Төсөвт байгууллага-1

-ААНБ-1

-Айл өрх-3 /засвар үйлчилгээний дуудлага/

-Цэвэр усны дуудлага-1

2023 оны 04 дүгээр сарын 28-ний байдлаар борлуулалтын авлага **58,600,000** төгрөг байна. Үйл ажиллагаа хэвийн өвөлжилтийн бэлтгэл ажлууд төлөвлөгөөний дагуу цаг хугацаандаа хийгдэж байна.





***МЭДЭЭНИЙ ЭХИЙГ БЭЛТГЭСЭН ЗДТГАЗРЫН ДАРГА В.ГАНТУЯА***